

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 8-ны өдөр

№ 21/38

Улаанбаатар хот

Үнэт цаас нийтэд санал болгон гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 сарын 11-ний өдрийн 226 тоот “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэх журам”, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2021 оны 2 сарын 5-ны өдрийн 21/08 тогтоолоор батлагдсан “Компанийн 2021 оны эх үүсвэрийн төлөвлөгөө”, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 10 сарын 8-ны өдрийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын тооллогын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Компанийн өрийн бичиг (цаашид “ЛэндБонд”)-ийг нийтэд санал болгон гаргахаар шийдвэрлэсүгэй.
2. Нийтэд санал болгох ЛэндБондын хэмжээ, ерөнхий нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Компанийн ЛэндБондын эргэн төлөлтөд “АНД Глобал” ПиТиИ ЭлТиДи компани 100 хувийн баталгаа гаргаж буйг дурдсугай.
4. Компанийн ЛэндБондыг нийтэд санал болгон гаргах үйл ажиллагаатай холбогдуулан үнэт цаасны зах зээлд оролцогч бусад эрх бүхий этгээдтэй энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд холбогдох хэлцэл хийх, гэрээ байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
5. Компанийн ЛэндБондыг нийтэд санал болгон гаргахтай холбоотой судалгаа шинжилгээ хийх, тэдгээрийн үйл явц, хэрэгжилт, үр дүнг Компанийн ТУЗ-д танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.
6. Компанийн ЛэндБондыг нийтэд санал болгон гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, шаардлагатай зөвшөөрөл, баримт бичгийг бүрдүүлэх, бусад шаардлагатай арга хэмжээ авах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 8-ны өдөр

№ 21/39

Улаанбаатар хот

Андеррайтер сонгох, гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2021 оны 10 сарын 8-ны өдрийн 21/38 тоот тогтоол, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 10 сарын 8-ны өдрийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын тооллогын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компаниас нийтэд санал болгон өрийн бичиг гаргах үйл ажиллагаанд хамтран ажиллах ерөнхий Андеррайтераар “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК-ийг сонгосугай.
2. “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК-тай байгуулах Андеррайтерийн гэрээний нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталж, гэрээ байгуулах, түүнд гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын 2-т заасантай холбогдуулан “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК-тай байгуулах Андеррайтерийн гэрээний хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 8-ны өдөр


№ 21/40

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.4 болон 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн Үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.12 дахь хэсэг, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 10 сарын 8-ны өдрийн 21/39 тоот тогтоол, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 10 сарын 8-ны өдрийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын тооллогын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компаниас нийтэд санал болгон өрийн бичиг гаргах үйл ажиллагаанд Андеррайтераар ажиллах “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК нь “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-ийг өөрийн Синдикатаар сонгож, хамтран ажиллахаар болсныг дурдсугай.
2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан Андеррайтер “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК-тай байгуулах Андеррайтерийн гэрээнд Синдикат “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-ийг оролцуулан гурвалсан хэлбэрээр гэрээ байгуулах, түүнд гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 8-ны өдөр

№ 21/41

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 сарын 11-ний өдрийн 226 тоот “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.16 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2021 оны 10 сарын 8-ны өдрийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын тооллогын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компаниас нийтэд санал болгон өрийн бичиг гаргах үйл ажиллагаатай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 сарын 11-ний өдрийн 226 тоот “Компанийн өрийн хэрэгслийг бүртгэх журам”-д заасан шаардлагын дагуу Компаниас 2021 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайланд “Мэжик консалтинг аудит” ХХК-аар хийлгэсэн аудит, гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Компанийн 2021 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.

